



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 24

№ 3/4

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

Хотын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дүрмийг хавсралт ёсоор
баталжугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХӨРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Л.ЭНЭВИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хур-
лын гүйцэтгэх захиргааны 1991
оны 3/4 дугаар тогтоолын
хэвсрэлт

УЛААНБААТАР ХОТЫН АХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ДҮРЭМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь Улаанбаатар хотын хэмжээнд гал түймэртэй тэмцэх нэгдсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх асуудал эрхлэх засаг захиргааны байгууллага мөн.

2.Хэлтсийн үндсэн зорилт нь иргэдийн амь нас,улс ардын аж ахуй болон хувийн нүүс, үйлдвэр, хоршооны аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх ажлыг хангамад оршино.

3.Хэлтэс нь үйл ажиллагаандаа БН.АУ-ын хууль тогтоомж,дүрмийг удирдлага болгоно.

4.Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх хяналтыг Гал түймэртэй тэмцэх хэлтэс түүний харьяа тасаг,салбар, улсын байцаагч нар хэрэгжүүлнэ.

5.Гал түймэртэй тэмцэх хэлтэс өөрийн зорилтыг биелүүлэхдээ хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаа, үйлдвэр, албан байгууллагын удирдлага,хөдөлмөрийн хамт олон, иргэдтэй нягт харилцан ажиллаж төр захиргааны байгууллага ард иргэдийн өргөн туслалцаанд тулгуурлана.

6.Гал түймэртэй тэмцэх хэлтэс үйл ажиллагаандаа удирдлагын шинжлэх ухааныг өргөн хэрэглэж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах ажилд шинжлэх ухаан техникийн орчин үеийн ололт бусад орны амжилт,туршлагыг судлан нэвтрүүлж ажиллана.

ХОЁР.Гал түймэртэй тэмцэх хэлтсийн зохион байгуулалт

1.Гал түймэртэй тэмцэх хэлтсийн даргыг ЦЕГ-ын саналыг үндэслэн АХТЗ-ны гишүүдийн хурлаар батлана.

2.Хэлтэс нь хотын гал түймэртэй тэмцэх салбар, гал унтраах анги, хэсгийг удирдах төв байгууллага бөгөөд өөрийн ажлаа Улаанбаатар хотын АХТЗ, Гал түймэртэй тэмцэх газрын өмнө хариуцна.

3.Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас хэлтсийн орон тоо,цалингийн санг баталж,хэлтсийн дарга нь Гал түймэртэй тэмцэх салбар,гал унтраах анги,хэсгийн улирагчдыг томилно.

2.

4. Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь хариуцлагатны зөвлөлтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь унтраах алба, урьдчилан сэргийлэх, захиргаа аж ахуйн тасаг, соёлын болон үйлдвэр эрчим хүчний салбар ажиллана.

5. Хотын гал унтраах анги, хэсгийг байгуулах татан буулгах, зэрэглэлийг өөрчлөх асуудлыг Гал түймэртэй тэмцэх газартай зөвшөөрөлцсөний үндсэн дээр хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэж байна.

6. Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаа гал түймэртэй тэмцэх хэлтсээс ажлаа зохион байгуулж явуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

7. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга БМАУ-ын Хууль тогтоомжид тулгуурлан эрх хэмжээнийхээ дотор тушаал заавар гаргах тэдгээрийн гүйцэтгэлд хяналт тавина.

8. Хэлтэс, тасаг, анги нь тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, улсын байцаагч нар үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэнэ.

ГҮРАВ. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн
үүрэг, эрх

1. Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ.

а. улсын онц чухал болон гал аюултай үйлдвэрийн технологийн процессын галын аюулгүйн байдал, шинээр баригдах, засвар, өргөтгөл хийх барилгын зураг төсөл, барилгын норм, дүрмийн шаардлагыг биелүүлж байгаа байдалд хяналт тавих.

б. гал унтраах автомат тоног төхөөрөмж, усан сан, худаг гидрант, зам гарц, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдал шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах.

в. улс, олон нийт, хоршоолол, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллага, хувийн нүүс үйлдвэр, гэр орон сууцанд гарсан гал түймрийн шалтгааныг илрүүлэн акт тогтоож, хэрэг бүртгэлтийг явуулах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах.

г/ гал түймэртэй тэмцэх хэлтэс, мэргэжлийн албадын хоорондын ажлын уялдааг зохицуулан хэтийн хөгжлийн төлөвийг тодорхойлох, байршлыг холбогдох байгууллага, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх.

е/ гал түймэртэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, техникийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, шинэ техник, завсэглэмж, сэлбэг хэрэгслийн талаар захиалга өгөх.

ё/ гал түймэртэй тэмцэх асуудлаар олон улсын ижил мэргэлийн байгууллагатай харилцах.

з/ улсын болон хувийн нүүс, үйлдвэр, хоршоо, аж ахуйн газрын галын аюулгүй байдалд хяналт тавих.

ж/ гал түймэртэй тэмцэх байгууллагын бие бүрэлдэхүүний хөдөлмөрийн нөхцөл хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн ажиллагаанд судалгаа хийж, түүнийг сайжруулах арга хэмжээ, нэгдсэн сургалтыг системтэйгээр зохион байгуулж хэрэгжүүлэх.

и/ хотын гал түймэртэй тэмцэх хэлтсийн тасаг, анги, салбар нь хэлтсийн шууд удирдлаганд ажлаа явуулна.

к/ гал түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг хөдөлмөрчид, хүн амын дунд төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж санамж, анхааруулга, зурагт хуудас хэвлүүлэх, ном товхимол гаргах.

2. Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь дор дурдсан эрх эдлэнэ.

а/ Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас баталсан цалингийн санд багтаан өөрийн аппаратын бүтэц, орон тоог зохицуулан ажиллах.

б/ Гал унтраах анги, хэсгийг байгуулах, зэрэглэл, орон тоо нормативыг өөрчлөх, татан буулгах талаар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд санал оруулах;

в/ гал түймэртэй тэмцэх ажлын холбогдолтой мэдээ, бичиг баримт, тодорхойлолт материалыг холбогдох яам, улсын хороо, тусгай газар, хот, районы ардын хурлын гүйцэтгэх захиргаа, улс, олон нийт, хоршоо, үйлдвэр, аж ахуйн газар, хувийн үйлдвэр, иргэдээс гаргуулан авах;

г/ галын аюулгүй байдлыг шалгах, хэрэг, учралын шалтгааныг илрүүлж тогтоох зорилгоор улс, олон нийт, хоршоо, үйлдвэр, аж ахуйн газар хувийн үйлдвэр, иргэдийн гэр, орон сууцанд нэвтрэн орох;

д/ гал түймрийн аюул гарах нөхцөлийг бүрдүүлсэн үйлдвэр, байгууллага, шинээр баригдаж байгаа барилга, объектын ажиллагааг түр бүхү бүрмөсөн зогсоох.

е/ гал түймэртэй тэмцэх, таслан зогсоох хойшлуулшгүй тохиолдолд улс, олон нийт, хоршоо, үйлдвэр, аж ахуйн газар хувийн үйлдвэр, иргэдэд байгаа холбооны хэрэгслийг үнэ төлбөргүй хэрэглэх.

ж/Гал түймэр гарсан хэргийн газарт хэрэлсэн очиж, хохирогчдод эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, гэмт хэрэгтэн, хохирогчдыг зохих байгууллагад хүргэх хойшлуулштгүй тохиолдолд дипломат албаны автомашинаас бусад авто болон ердийн тээврийн хэрэгслийг дайчлан ашиглах.

з/гал түймэр унтраахад усны нөөц дутагдвал ус тээвэрлэгч машиныг дайчлах;

к/байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд томоохон гал түймэр нээр 4 цагаас дээш хугацаагаар ажилласан бүрэлдэхүүнд халуун хоол, гайгаар үйлчлүүлсний зарцыг тухайн байгууллагаас нэхэмжлэн гаргуулах.

3.Гал түймэртэй тэмцэх хэлтсийн улсын байцаагчийн акт, албан шаарцлага мэдэгдлийн хариуг улс, олон нийт, хоршоо, үйлдвэр, аж ахуйн газар, хувийн үйлдвэр, албан тушаалтан, иргэдээс тогтоосон хугацаанд албан ёсоор гаргуулан авч байна.

4.Гал түймэртэй тэмцэх хэлтсийн улсын байцаагчийн төвсөн акт, шаарцлага, торгуулийг тухайн албан тушаалтан, иргэд зөвшөөрөхгүй тохиолдолд гомцлоо 7 хоногийн дотор Галтүймэртэй тэмцэх хэлтэст гаргаж болно.

Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь уг гомцлыг хүлээж авсан өдрөөс хойш 4 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.Хэрэв энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл Гал түймэртэй тэмцэх газар, Прокурорт гомдол гаргаж болно.

УЛААНБААТАР Х.СҮНН АХТЗ-НИ ГАЛ
ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ Х.ЛТЭС